



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019. 01-18 № 01

Асуулга тавих тухай

Монгол улс 1991 онд ОУВС-гийн гишүүнээр элсэн орсон бөгөөд манай Засгийн газрын өмнө тулгарсан эдийн засгийн хүнд хэцүү үед нийтдээ ОУВС-аас зургаан удаа санхүүжилт авч байжээ. Мөн нөхцөл зөөлөн "Стэнд бай" хөтөлбөрт хоёр удаа хамрагдсан /1991 онд 13.75 сая ам.доллар, 2009 онд 229.2 сая ам.доллар/. 2017 онд Монгол улсын Засгийн газар Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр буюу "EFF" хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ өргөн барьснаар ОУВС энэ хүсэлтийг судалж үзээд 2017 оны тавдугаар сараас хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Нийтдээ 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт хийгдэхээс ОУВС-гаас 430 гаруй сая ам.доллар, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Япон, БНСУ зэрэг хоёр талт түншүүдээс нийтдээ 3 тэрбум ам.долларын дэмжлэг үзүүлэхээр болсноо зарласан.

Гэтэл 2016 оны эцсээр урд хөршийн эдийн засаг сэргэж, манай валют олдог голлох эрдэс бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнэ ханш өсч эхэлсэн. Ийнхүү уул уурхайн мөчлөг дагасан эдийн засгийн уналт зогсож, сэргэлт эхэлсэн таатай он жил эхлэх нь тодорхой болсон байв. Гэвч 2016 онд УИХ-ын сонгуулиар шинээр байгуулагдсан Засгийн газрын Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгч нар "эдийн засаг дампуурсан", "валютын нөөц сөрөг утгатай болсон" мэтээр улс төржсөн мэдэгдэл хэд хэдэн удаа санаатайгаар хийсэн. Энэ нь хямралыг бие даан амжилттай даван туулсан тухайн үеийн эрх баригч хүчин болох Ардчилсан намын үйл ажиллагааг "шавартай хутгах" замаар ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдаж, улмаар асар их хэмжээний санхүүжилт авах зорилготой байсантай нь холбон тайлбарлахаас өөр аргагүй юм.

2017 онд экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортын орлого 3.4 дахин, төмрийн хүдрийн экспортын орлого 40 хувиар нэмэгдсэн. Уул уурхайн экспортын голлох 6 бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ 2016 оны 6 дугаар сард нийт дүнгээрээ 1.8 тэрбум ам.доллар байсан бол 2017 оны эцсээр 5.3 тэрбум ам.долларт хүрч, эдийн засгийн сэргэлтийн мөчлөг ирсэн гэдгийг баталсан. Эдийн засгийн өсөлт 2018 оны хагас жилийн байдлаар 6.1 хувьд хүрэв. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханш нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүн эрэлттэй байгаа нь Монгол Улсын эдийн засагт сэргэлт авчирсан гэдэгтэй ОУВС, Дэлхийн банк санал нэг байгааг тэдний гаргасан тайлангуудаас харж болно. Үүнээс гадна Олон улсын санхүүгийн байгууллага, донор орнуудаас их хэмжээний валют манай эдийн засагт урсан орж ирж байгаа. Зөвхөн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 728 сая ам.доллар, 2018 онд 836 сая ам.доллар орж ирэх учиртай. Эдийн засгийн

ийм таатай нөхцөл Монгол улсын түүхэнд цөөхөн удаа тохионо. Гэвч 2018 онд шатахууны үнэ нэмэгдэж, төгрөгийн ханш суларч байгаа нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэд шууд нөлөөлж, өдөр хоногоо залгуулж буй иргэдэд туйлын хүндээр тусч эхэлснийг Нийслэлийн статистикийн газраас гаргадаг мэдээнээс харж болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. ОУВС гол анхаарлаа хандуулдаг эдийн засгийн үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл, гадаад өр, төсвийн алдагдлын хэмжээ зэрэг макро үзүүлэлтүүд хөтөлбөр хэрэгжсэн 2 жилд ямар үр дүнд хүрсэн талаар тодорхой тайлан ирүүлэх,

2. ОУВС-ын онилдог гол үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 9 сард 475.3 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 677.2 сая ам.доллараар өслөө. Ийнхүү төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсанд Засгийн газрын алдаа байгаа эсэх талаар,

3. Монгол улсын нийт гадаад өр 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 24.3 тэрбум ам.доллар байсан бол 2018 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 27.9 тэрбум ам.долларт хүрч 3.6 тэрбум ам.доллараар, харин Засгийн газрын өр энэ хугацаанд 4 их наяд 471 тэрбум төгрөгөөр нэмэгдээд байна. Мөн Төв банкны үнэт цаас 4 их наяд 371 тэрбум төгрөгөөр өссөн байна. Ийнхүү Монгол улсын нийт өр төдийгүй Засгийн газрын өр нэмэгдэж байгаа учир шалтгааны талаар,

4. 2019 оны нэгдсэн төсвийн алдагдал 1 их наяд 913 тэрбум төгрөг байхаар тооцож оруулж ирснийг багасгах боломж байсан эсэх талаар,

5. Сүүлийн саруудад ам.долларын эсрэг төгрөгийн ханш эрчимтэй суларч, Монголбанк 2018 онд нийтдээ 1.4 тэрбум ам.долларын интервенци хийсэн боловч төгрөгийн ханшийн огцом хэлбэлзлийг бууруулж чадахгүй хяналтаа бүрэн алдаад байна. Мөн инфляц 2018 оны урьдчилсан дүнгээр Улаанбаатар хотод хоёр оронтой тоонд хүрч эхэллээ. Ийнхүү ОУВС анхаарлаа хандуулдаг гол үзүүлэлтүүд туйлын тааруу байгаад Засгийн газрын үйл ажиллагаа нөлөөлж байгаа эсэх талаар,

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б. ПҮРЭВДОРЖ